

Эдийн засгийг эрчимжүүлэх 10 их наядын бодлогын хувийн секторт үзүүлсэн үр нөлөө ба хэрэгжилтийн сургамж

З. Манлайбаатар
Д. Оюунтөгс
У. Энхсайхан
С. Отгонбат

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ЭЗСЭШХ)

Хураангуй

USAID-ын санхүүжилттэй Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрийн захиалгаар “Цар тахлын үеийн эдийн засгийн бодлого: Өнгөрсөн ба ирээдүй” төслийг 2022 оны 5-р сараас 9-р сарын хугацаанд хэрэгжүүлэв. Төслийн хүрээнд гурван цуврал сэдвээр судалгаа хийж, сэдэв тус бүр дээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Эхний судалгаа нь “Эдийн засгаа эрчимжүүлэх хөтөлбөрийн хувийн секторын үр нөлөө, сургамж” сэдэвтэй бөгөөд энд Засгийн газраас 2021 онд хэрэгжүүлсэн Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн талаарх судалгаа, статистик тоон мэдээлэл, тайлангуудад тойм шинжилгээ хийсэн.

Түлхүүр үгс:

Ковид-19, хувийн сектор, хариу арга хэмжээ, Монгол Улс

Улаанбаатар, Монгол

2022



**ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА,
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХҮРЭЭЛЭН**

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ

**ЭДИЙН ЗАСГИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ
10 ИХ НАЯДЫН БОДЛОГЫН
ХУВИЙН СЕКТОРТ ҮЗҮҮЛСЭН
ҮР НӨЛӨӨ БА ХЭРЭГЖИЛТИЙН СУРГАМЖ**

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**

Агуулга


Оршил	3
1. Цар тахлын үеийн эдийн засгийн нөхцөл байдал	5
1.1. Макро эдийн засгийн төлөв.....	5
1.2. Ажил эрхлэлт ба өрхийн амьжиргаа	9
1.3. Банкны зээл.....	13
2. Эдийн засгийг эрчимжүүлэх 10 их наядын бодлогын хэрэгжилт ба үр нөлөө	17
2.1. Бодлогын хэрэгжилт	17
2.2. Бодлогын үр нөлөө.....	24
3. Бодлогын дүгнэлт, сургамж	32
Ашигласан эх сурвалж	33

Оршил

2019-2020 оны заагаас эхлэн дэлхий даяар дэгдсэн Ковид-19 цар тахлын улс орнуудын эдийн засаг, хүн амын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөө өнөөг хүртэл үргэлжилж байна. Манай улсад Ковид-19-ийн бүртгэгдсэн тохиолдол 2022 оны 5-р сарын 25-ны байдлаар 476'885, нас баралт 2'179 хүрээд байна. Цар тахлын улмаас эдийн засаг 2020 онд 4.6% агшсан бол 2021 онд дөнгөж 1.4% өссөн.

Цар тахлын дэгдэлтээс сэргийлж Монгол Улсын Засгийн газар 2020 оны 1-р сарын 27-нд өндөржүүлсэн бэлэн байдал зарласнаас хойш хоёр жилийн дараа 2022 оны 2-р сарын 14-нд онцгой байдлын энэ түвшнийг цуцалсан билээ. Энэ хугацаанд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан улс хоорондын зорчигч болон ачаа тээвэр, хот хоорондын хөдөлгөөнийг хязгаарлах, сургууль цэцэрлэгийг хаах, үйлчилгээний газрын цагийг хязгаарлах, хот суурин газарт хатуу хөл хорио тогтоох гэх мэт олон төрлийн хязгаарлалтын арга хэмжээг авч ирсэн. Ялангуяа, дотоодод халдвар дэгдсэн 2020 оны 11-р сараас 2021 оны 5-р сарын хооронд нийт 4 удаа 1-4 долоо хоног үргэлжилсэн бүх нийтийн хатуу хөл тогтоосон билээ (Зураг 1).

Зураг 1. Ковид-19-ийн бүртгэгдсэн тохиолдол ба онцгой байдлын нөхцөл



Эх сурвалж: <https://www.worldometers.info/coronavirus/country/mongolia/>

Бизнесийн үйл ажиллагааны шууд хязгаарлалтаас гадна ажиллагсад халдварт өртөх, борлуулалт буурах, орц, түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээ тасалдах, бараа түүхий эдийн үнэ өсөх, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал өсөх, шинэ орчинд дасан зохицох гэх мэт хүндрэл сорилтуудтай бизнес эрхлэгчид нүүр тулж ирсэн.

Монгол Улсын Засгийн газар 2021 оны 2 дугаар сарын 17 өдрийн 42 дугаар тогтоолоор цар тахлын улмаас эдийн засаг, эрүүл мэндийн салбарт учрах эрсдэлийг хохирол багатайгаар даван туулж, тахлын өмнөх буюу хэвийн үе рүү аль болох хурдан хугацаанд хүрэх зорилготойгоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх арван их наядын цогц төлөвлөгөө”-г баталсан. Энэ төлөвлөгөө нь эрүүл мэндээ хамгаалах, эдийн засгаа сэргээх гэсэн хоёр үндсэн зорилготой байв. Үүнээс эдийн засгаа сэргээхтэй холбоотой 33 зорилт дэвшүүлсэн бөгөөд эдгээрийг ерөнхийд нь дараах байдлаар бүлэглэж болно. Үүнд:

1. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд жилийн гурван хувийн хүүтэй, гурван жилийн хугацаатай 2 их наяд төгрөгийн зээл

2. Залуучуудыг ажил, мэргэжилд бэлтгэх, эрүүл чийрэг, идэвхтэй амьдралын хэв маягт хөтлөх хоёр сарын хугацаатай, сарын 500 мянган төгрөгийн тэтгэлэг, сургалтад хамруулахад 500 тэрбум төгрөг
3. Эхний ээлжид Улаанбаатар хотод баригдах “Залуус I, II, III” хорооллын дэд бүтэц, газар олгох, орон сууцыг нэг маягийн зургаар барих, ипотекийн хөнгөлөлттэй зээл олгох зэрэгт 3 их наяд төгрөг
4. Стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 2 их наяд төгрөг
5. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, малчдын орлого, амьжиргааг дэмжих зорилгоор 500 тэрбум төгрөг
6. Монголбанкны нэг жилийн хугацаанд олгох нэг их наяд төгрөгийн репо санхүүжилтийг 2 их наяд төгрөг болгож нэмэхээр тусгасан. Энэхүү нэг их наяд төгрөгийн нэмэлт санхүүжилтийн хүрээнд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгох 300 сая төгрөгийг 500 сая, уул уурхайн бус экспортын үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох нэг тэрбум төгрөгийг 3 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлнэ.

Засгийн газрын тогтоолд дурдсанаар, батлагдсан төлөвлөгөөний хүрээнд банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх ажлын байрыг дэмжих зээлд хамрагдах аж ахуйн нэгжийн төлөх зээлийн нийт хүүгийн 9.0 нэгж хүртэл хувийг, иргэдийн төлөх зээлийн нийт хүүгийн 10.0 нэгж хүртэл хувийг, хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хүрээнд газар тариалан, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, ноолуур, ноос, арьс, шир бэлтгэл, үйлдвэрлэл, гурил, тэжээл, ургамлын тосны үйлдвэрлэлийн зээлд хамрагдах зээлдэгчийн төлөх зээлийн нийт хүүгийн 7.65 нэгж хувийг, малчдыг дэмжих зээлийн нийт хүүгийн 7.0 нэгж хувийг тус тус Засгийн газраас хариуцан төлөх юм.

Энэхүү бодлогын арга хэмжээ ерөнхийдөө бараг хэрэгжиж дууссан гэж үзэж байгаа боловч хөтөлбөрийн бодит хэрэгжилт, үр нөлөөний талаарх дэлгэрэнгүй танилцуулга, мэдээлэл хомс байна. Цогц төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, дүнг хагас жил тутам нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Сангийн сайдад даалгасан боловч уг мэдээлэл нийтэд төдийлөн нээлттэй биш байдаг. Иймээс уг хөтөлбөрийн нээлттэй тайлан мэдээлэл, явцын үеийн судалгаа, хөтөлбөрийн оролцогч болон үр шим хүртэгчдийн санал бодолд үндэслэн эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн хэрэгжилт, үр нөлөө, сургамжийн талаарх энэхүү тойм судалгааг гүйцэтгэж байна.

Судалгааны тайлангийн дараагийн бүлэгт эхлээд цар тахлын үеийн макро эдийн засгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж ирснийг дэлгэрэнгүй авч үзнэ. Харин 3-р бүлэгт эдийн засгийг эрчимжүүлэх бодлогын хэрэгжилт ямар түвшинд, хэрхэн явагдсан талаар болон уг бодлогын нийт эдийн засагт болон хувийн секторт үзүүлсэн үр нөлөөний талаар хэлэлцэнэ. Эцэст нь уг бодлоготой холбоотой дүгнэлт, цаашид анхаарах сургамж, бодлогын санал зөвлөмжийг дэвшүүлнэ.

1. Цар тахлын үеийн эдийн засгийн нөхцөл байдал

1.1. Макро эдийн засгийн төлөв


Эдийн засгийн өсөлт

2020 онд COVID-19 цар тахлын улмаас дэлхий даяар эдийн засгийн уналт тохиолдож, гадаад хүчин зүйлээс хүчтэй хамаардаг Монголын эдийн засагт ихээхэн хүндрэл тулгарсан билээ. 2020 оны эхний хагаст манай улсын гол түүхий эдүүдийн дэлхийн зах зээлийн үнэ унаж, экспорт саатаж, цар тахлаас сэргийлэх зорилгоор зорчигч ба ачаа тээвэр, үйлчилгээний салбарт хязгаарлалт байв. Харин 2020 оны сүүлийн хагаст түүхий эдүүдийн дэлхийн зах зээлийн үнэ өсөж, гадаад худалдааны үзүүлэлтүүд сайжирсан боловч дотоодод COVID-19-ийн халдвар дэгдсэнээр олон хоногийн хөл хорио тогтоосон. Үр дүнд нь 2020 онд Монгол Улсын эдийн засаг 5.3 хувь агшсан билээ.

2021 онд дэлхийн эдийн засгийн байдал харьцангуй тогтворжиж эхэлсэн боловч, дотоодод COVID-19-ийн нөхцөл байдал хүндэрч, халдварын тоо хурдацтай өсөж олон удаагийн хатуу хөл хорио тогтоосон. Мөн дотоодод цар тахлын дэгдэлт нэмэгдсэний улмаас ачаа барааны хил нэвтрэлт удааширч түүхий эдийн экспорт саатаж, импортын барааны үнэ өсөж, тээврийн салбарын үйлдвэрлэл буурч, дотоодын үйлдвэрүүд орц, түүхий эдийн хомсдолд өртөж, үйлдвэрлэл нь буурав. Мөн хаваржилт хүндэрсэн тул хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурсан. Үр дүнд нь ДНБ дөнгөж 1.4 хувиар өсжээ.

2021 оны эхний улиралд өсөлт 14.8% хүрч байсан бол II улирлаас хойш өсөлт саарсаар 2022 оны I улиралд -3.8% болов. 2021 оны III улирлаас хойш гурван улирал дараалан эдийн засаг агшив. 2022 он гарсаар БНХАУ-ын хилийн боомт дахь асуудал шийдэгдэхгүй хэвээр байгаа тул уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тасалдаж, үйлдвэрлэл буурч улмаар тээврийн салбарын үйлдвэрлэл үлэмж хэмжээгээр буурсан. Мөн дотоодод барилгын материалын үнэ хурдацтай нэмэгдсэнээр барилгын салбарын үйлдвэрлэл үлэмж хэмжээгээр буурав. Цаашлаад боловсруулах салбарын үйлдвэрлэл буурсан нь ДНБ буурахад голлон нөлөөлж ирлээ.

Зураг 2. Бодит ДНБ-ий өсөлт улирлаар, %



Эх сурвалж: YCX (www.1212.mn)


Эрэлтийн талаас авч үзвэл, өрх, төрийн байгууллагын хэрэглээ өсөж байгаа ч, үндсэн хөрөнгийн хуримтлал болон цэвэр экспортын алдагдал буюу урсгал тэнцлийн алдагдал өссөн нь эдийн засгийн өсөлт сөрөг гарахад голлон нөлөөлжээ.

2020 онд Монгол Улсын эдийн засгийн гол салбаруудын нэг болох уул уурхайн салбарын бодит үйлдвэрлэл 9.4% буурав. COVID-19 цар тахал уул уурхай, олборлох салбарт ихээхэн сөрөг нөлөө үзүүлсэн бөгөөд нүүрс болон газрын тосны үйлдвэрлэл эрс буурсан. Гэхдээ зэсийн баяжмалын үйлдвэрлэл өсөж, алт, төмрийн хүдрийн олборлолт огцом нэмэгдсэн нь уул уурхайн салбарын болзошгүй бууралтыг сааруулжээ.

COVID-19 цар тахлын улмаас бизнесийн үйл ажиллагаа тасалдаж, жилийн туршид эрэлт буурсантай холбоотойгоор 2020 онд боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бодит үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 хувиар буурчээ.

2020 онд цар тахалтай холбоотой хилийн хориг тавьж, үйлчилгээний зарим үйл ажиллагааг хязгаарлаж эхэлсэн. Улмаар, аялал жуулчлал хязгаарлагдаж, тээвэр, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний дэд салбарын үйлдвэрлэл буурсан. Энэ нь үйлчилгээний бусад салбарын үйлдвэрлэл буурахад хүргэв. Мөн уул уурхай, олборлолт зэрэг эдийн засгийн бусад салбарын үйлдвэрлэл хумигдаж, бусад салбарын эрэлт буурсан нь бөөний ба жижиглэн худалдааны эрэлтэд сөрөг нөлөөлж байв. Цаашлаад, хэрэглэгчдийн эрэлт хангалтгүй байгаагаас бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын орлого буурсан. Харин, 2020 онд ХАА салбарын бодит үйлдвэрлэл 6.2 хувиар өссөн ба тус салбар нь COVID-19 цар тахлын нөлөөнд өртөөгүй ганц салбар юм.

Зураг 3. Салбаруудын ДНБ-ний өсөлт дэх хувь нэмэр, %



Эх сурвалж: YCX (www.1212.mn)

2021 онд дотоод дахь цар тахлын тохиолдлын тоо нэмэгдэж, улмаар оны дунд үеэс эхлэн БНХАУ-ын талаас хилийн бүс нутаг дахь журмаа чангатгаж, 10-р сараас эхлэн хилийн хязгаарлалт тогтоосонтой холбоотойгоор нийлүүлэлтийн сүлжээ тасалдаж, ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт ихээхэн буурлаа. Үүнтэй холбоотойгоор уул уурхайн бүтээгдэхүүн тэр дундаа нүүрс, газрын тосны үйлдвэрлэл оны сүүлийн хагаст огцом буурсан. Улмаар, уул уурхайн салбарын үйлдвэрлэл 1.6%-аар өсөв.

Хэдийгээр 2021 онд хэд хэдэн удаа хатуу хөл хорио тогтоосон ч, вакцинжуулалт сайн явагдсан тул 2021 оны сүүлийн хагаст цар тахлын үеийн дэглэм суларч, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг сэргээснээр үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын орлого 2.2% өсөж, ДНБ-ний өсөлтөд эерэг нөлөө үзүүлэв. Мөн эдийн засгийн үйл ажиллагаанууд эрчимжиж эхэлснээр бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын эрэлт өсөж, тус салбарын үйлдвэрлэл 9.3% өсөв.


Харин 2021 онд өвөлжилт хүндэрч, малын хорогдол өссөнөөр хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 5.5 хувиар буурсан. Мөн хилийн боомт дахь асуудлаас улбаатай барилгын материалын хомсдол болон барилгын материалын дэлхийн зах зээлийн үнэ өссөн зэргээс шалтгаалан барилгын салбарын үйлдвэрлэл 32.7% буурсан зэрэг нь ДНБ-ий өсөлтийг сааруулав.

2022 он гарсаар хилийн боомтын асуудал шийдэгдэхгүй хэвээр байгаа нь уул уурхайн салбарын олборлолт, борлуулалтад сөргөөр нөлөөлж улмаар тус салбарын үйлдвэрлэл 2022 оны эхний улиралд 2021 оны эхний улиралтай харьцуулахад 37% -аар буурсан. Энэ нь 2022 оны эхний улиралд бодит ДНБ буурахад голлох нөлөөг үзүүлэв.

Инфляц

2020 онд эдийн засгийн идэвхжил саарч, хүнс, барааны үнийн өсөлт харьцангуй бага байж, Засгийн газраас шатахууны үнийг тогтвортой барьж байснаас инфляц бага түвшинд байсан. Харин 2021 оны II улирлаас хойш инфляц тасралтгүй өсөж байгаа ба 2022 оны I улирлын байдлаар 14.4 %-д хүрээд байна. 2021 оны II улиралд Засгийн газраас иргэдийн амьжиргааг дэмжихийн тулд иргэн бүрд 300 мянган төгрөг, тэтгэврийн зээлгүй ахмадуудад 1 сая төгрөг хуваарилсан, 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл олгосон зэрэг нь эрэлтийн талаас инфляцыг өдөөсөн. Харин 2021 оны 7 сараас хойш, шатахууны үнэ огцом нэмэгдсээр байгаа. Мөн 2021 оны II улирлаас хойш дотоодод цар тахлын дэгдэлт өндөр байснаас хил нэвтрэх ачаа тээврийн хөдөлгөөн хязгаарлагдаж, хүнс, өргөн хэрэглээ, барилгын материалын импорт саатаж байгаа нь үнийн өсөлтөд нөлөөлж байв. Цаашлаад, дэлхий даяар хүнсний бүтээгдэхүүний үнэ, тээвэрлэлтийн зардал өсөж байсан нь импортын бүтээгдэхүүний үнийг өсгөж, инфляц өсөх нэг шалтгаан болж байна. Мөн 2022 оны хоёрдугаар сард Украин-ОХУ-ын дайн эхэлснээр олон улсын харилцаанд хурцадмал байдал үүсэж, шатахуун, хүнс болон бусад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг өдөөв.

Зураг 4. Улсын инфляц ба дэлхийн хүнсний үнийн индекс, %




2022 оны I улирлын байдлаар 14.4 %-д хүрсэн бөгөөд үүний 51.9 %-ийг импортын барааны үнийн өсөлт тайлбарлаж байна (Зураг 4). Барааны бүлгээр задлан харвал, хүнсний барааны үнэ өмнөх оны мөн үеэс 18%, тээврийн үйлчилгээний үнэ 23.8%, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний үнэ 14.8%, орон сууц, ус, цахилгаан, түлшний үнэ 14.7%, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний үнэ 14.2%, хувцас, бөс бараа, гутлын үнэ 11.5%, гэр ахуйн тавилга, барааны үнэ 12.4% тус тус өссөн.

2020 онд эдийн засгийн идэвхжил буурч, инфляц нам дор түвшинд хүрсэн тул Монголбанк 2020 оны 11 сард мөнгөний бодлогын хүүг 6% болгон бууруулж байв. 2021 онд эдийн засгаа сэргээх, эрчимжүүлэхийн тулд мөнгөний бодлогын хүүг тогтвортой түвшинд хадгалж байсан. Харин 2022 он гарснаар мөнгөний бодлогын хүүг өсгөж эхэлсэн. Монголбанкнаас үүсээд байгаа олон улсын харилцаанаас шалтгаалсан тодорхойгүй байдал нэмэгдэж байгаа, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, тээвэр логистикийн асуудаас үүдэлтэй инфляц эрчимжих, үүнийг дагасан үйлдвэрлэлийн зардал өсөх, улмаар зардлын инфляц болох, инфляцын хүлээлт өсөх, гадаад суурь хүү өсөх нөхцөл үүсэж байна гэж дүгнэсэн. Улмаар 2022 оны 3 сарын 24-ний өдөр мөнгөний бодлогын хүүг 9%-д хүргэж огцом нэмэгдүүлэв.

Мөнгөний нийлүүлэлт

2020 оны эхний улиралд M2 мөнгөний нийлүүлэлтийн өсөлт хамгийн бага түвшинд буюу 4%-д хүрсэн байна. Үүнд төгрөгийн хадгаламжийн хэмжээ буурсан нь хамгийн их нөлөөг үзүүлсэн байна. Цар тахлын тодорхойгүй нөхцөл байдал үүссэнээр иргэдийн хадгалах хандлага өсөж эхэлсэн. Мөн тахлын үед Засгийн газраас тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлсэн. Ингэснээр, 2020 оны III улирлаас иргэдийн валютын болон төгрөгийн хадгаламж хурдтай өсөж эхэлсэн. Цаашлаад, 2021 оны II улиралд иргэдийн хадгаламж болон, харилцах дансанд байх мөнгөний хэмжээ хурдацтай өссөнөөр, M2 мөнгөний өсөлт 30 %-д хүрч байв. Үүнээс хойш, цар тахлын тодорхойгүй байдал намжиж, хүмүүс хэвийн амьдралдаа буцаж орохын хэрээр хүмүүсийн хуримтлах хандлага буурч байна. Түүнчлэн хүү буурсантай холбоотой хүмүүсийн хугацаатай хадгаламж хийх сонирхол буурчээ. Иргэдийн хадгаламжийн өсөлт саарснаар, 2022 оны эхний улиралд M2 мөнгөний өсөлт саарч 5%-д хүрч, мөнгөний нийлүүлэлт 26.5 их наяд төгрөгт хүрсэн.

Зураг 5. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа, %



2021 оны жилийн эцсийн байдлаар M2 мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 15.0%-аар, өмнөх улирлаас 3.2% өсөж 27.9 их наяд төгрөгт хүрэв. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд төгрөгийн хадгаламж болон харилцах нөлөөлсөн хэвээр байгаа ч мөнгөний нийлүүлэлтийн өсөлт бага зэрэг буурч эхлэв.


Өмнөх улиралд хугацаатай хадгаламжийн өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн дийлээхийг тайлбарлаж байсан бол тайлант улиралд төгрөгийн харилцахын өсөлт нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн гол тайлбарлагч болж байна. Төгрөгийн харилцах өмнөх улирлаас 17.7%-аар, өмнөх жилийн мөн үеэс 64.3%-аар нэмэгджээ.

1.2. Ажил эрхлэлт ба өрхийн амьжиргаа

Ажил эрхлэлт

Хэдийгээр 2020 онд эдийн засгийн идэвхжил суларсан байсан ч ажиллагчдын тоо харьцангуй тогтвортой, ажиллах хүчний оролцоо COVID-19-ийн өмнөх үетэйгээ ойролцоо байсан. Харин 2020 оны сүүлийн улирлаас ажиллагчдын тоо буурч, ажиллах хүчний оролцооны түвшин буурч, ажилгүйдэл өсөж эхэлсэн. Улмаар 2021 оны эхний улиралд ажиллах хүчний оролцоо хамгийн доод түвшинд буюу 54.9%-д хүрч, ажилгүйдлийн түвшин 8.8%-д хүрсэн. 2021 оны II улирлаас ажиллах хүчний оролцоо нэмэгдэж, ажиллагчдын тоо өсөж, ажилгүйдэл буурч эхэлсэн боловч COVID-19-өөс өмнөх түвшинд хүрээгүй байна. Энэхүү ажиллах хүчний оролцоо, ажиллагчдын тоо өсөж, ажилгүйдэл буурсан нь вакцинжуулалт идэвхтэй явагдаж, хаалттай байсан зарим салбаруудын үйл ажиллагааг нээж, 10 их наядын хөтөлбөр хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотой байв.

Зураг 6. Ажиллах хүчний тоон үзүүлэлтүүд, мянган хүн




Эх сурвалж: YCX, 1212.mn

2021 оны эхний улиралд ажилгүйдэл өсөж, ажиллах хүчний оролцоо буурч байсан боловч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо мөн өсөж байв. Өөрөөр хэлбэл, ажлын байраа алдсан иргэд зарим нь ажилгүйчүүдийн эгнээнд нэгдсэн бол, зарим хэсэг нь ажиллах хүчнээс гадуурх хүн болсон. Тухайлбал, 2021 оны эхний улиралд ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үетэй харьцуулахад 77.7 мянган хүнээр нэмэгдсэн бол, ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 18.5 мянган хүнээр нэмэгдэж байж. Үүнээс харахад COVID-19-ийн нөлөөгөөр ажилгүй болсон иргэдийн дийлэнх хэсэг нь ажиллах хүчнээс гадуурх хүн амд орсон байна.


Зураг 7. Ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, %



Эх сурвалж: YCX, 1212.mn

2020 оны сүүлийн улирлаас ажиллах хүчний үзүүлэлтүүд муудаж эхэлсэн бөгөөд, ажилтай боловч сүүлийн 7 хоногт ажиллаагүй ч буцаж хийхээр хүлээгдэж байгаа иргэдийн тоо огцом өсөв. Энэхүү хандлага 2021 оны II улирал хүртэл үргэлжилсэн бөгөөд эдгээр иргэдээс ковидын улмаас ажил хийх боломжгүй болсон иргэдийн эзлэх хувь өндөр (65%-80%) байв. Тухайлбал, 2020 оны IV улиралд цар тахлын улмаас ажил хийх боломжгүй болсон иргэдийн тоо 124.7 мянгад хүрч байв. 2021 оны II улиралд энэхүү иргэдийн тоо 80.7 мянгад хүрч байсан бол үүнээс хойш тасралтгүй буурч, 2021 оны эцэст 4.5 мянгад хүржээ.


Зураг 8. Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлээгүй ч хүлээгдэж байгаа ажиллагчид, улирлаар, мянган хүнээр



Эх сурвалж: YCX, Ажиллах хүчний түүвэр судалаа-2021

Эдийн засаг агшиж байсан 2020 онд салбаруудын ажил эрхлэлт төдийлөн буураагүй бол 2020 оны сүүлээс буурч эхэлсэн. 2021 оны эхний улиралд ажил эрхлэлт хурдацтай буурсан бөгөөд үүний дийлэнх хэсэг нь худалдааны салбараас бусад төрлийн үйлдчилгээний салбарт ажиллагсадын ажил эрхлэлт буурсантай холбоотой байв.


Зураг 9. Салбаруудын ажил эрхлэлт, мянган хүн



Эх сурвалж: YCX, 1212.mn

10 их наядын хөтөлбөрт ихээр хамрагдсан салбаруудын ажил эрхлэлтийг дараах зурагт харуулав. Хөдөө аж ахуйн салбарын хувьд 2020 онд ажил эрхлэлт нь буурч байсан бол 2021 онд өсөлттэй байв. Харин бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын ажил эрхлэлт 2020 онд өсөлттэй байсан бол 2021 онд буурав. Харин барилгын салбарын хөдөлмөр эрхлэлт 2020 оны III улирлаас буурч эхэлсэн бол 2021 оны III улирлаас өсөж эхэлжээ.

Зураг 10. ХАА, Барилга, бөөний, жижиглэн худалдааны салбаруудын ажил эрхлэлтийн өсөлт, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар




Эх сурвалж: YCX, 1212.mn

2020 онд жилийн дүнгээр өрхийн бодит хэрэглээний өсөлт саарч 2.7% өслөө. Энэ нь хөл хорио тогтоож, эдийн засгийн эрчимжилт суларч, орлого буурсантай холбоотой байв. Харин 2021 онд өрхийн бодит хэрэглээ 6.65% буурсан бөгөөд энэ инфляцын өсөлт болон болон цар тахлын

тодорхойгүй нөхцөлд өрхүүд орлогоо хэрэглэхээс илүүтэй хадгалах хандлагатай байсантай холбоотой байв. Үүнийг 2021 онд нийт төгрөгийн хадгаламжийн өсөлт өндөр байснаас харж болно(Зураг 5).

2020 оны онд өрхийн дундаж орлого 2019 онтой харьцуулахад өсөөд байсан ба энэ нь Засгийн газраас цар тахлын үед эдийн засгийг эрчимжүүлэхийн тулд хүүхдийн мөнгө, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байсан. Харин 2020 оны сүүлч 2021 оны эхээр өрхийн орлого буурсан нь эдийн засгийн салбаруудын үйлдвэрлэл буурч улмаар, ажилгүй хүмүүсийн тоо нэмэгдэж, иргэдийн цалингийн орлого буурсантай холбоотой байв. 2021 оны II улирлаас хойш өрхийн орлого нэмэгдсээр байгаа. Үүнд 2021 онд Засгийн газрын тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлсэн, иргэдийн зээлийн төлбөрийг хойшлуулсан, цахилгаан дулаан зардлыг төрөөс хариуцсан, шахмал түлшний үнэд хөнгөлөлт үзүүлэх зэрэг бодлого хэрэгжсэн хэвээр байгаа нь хамгийн их нөлөө үзүүлж байв.

Зураг 11. Өрхийн дундаж орлого, зарлага, нэрлэсэн дүнгээр, сая төгрөг



Эх сурвалж: YCX, 1212.mn

2020 онд өрхүүдийн хэрэглэх хандлага орлогын өсөлттэй уялдаатай байсан бол 2021 онд өрхүүд Засгийн газраас авсан тэтгэвэр, тэтгэмжийн нэмэлт орлого, хэмнэсэн зардлаа илүүтэй хадгалж эхэлсэн. 2021 онд өрхүүдийн орлого зарлагаа давсан. Гэсэн хэдий ч, 2021 оны сүүлийн саруудад инфляц эрчимжсэнээр, 2022 оны эхний улиралд, өрхийн зарлага огцом өсөв.

1.3. Банкны зээл

Ковид-19 цар тахлын эсрэг Монголбанкнаас эдийн засаг болон санхүүгийн салбарын тогтворгүй байдал, уналтыг бууруулах, саармагжуулах олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Төв банкны анхаарал хандуулж буй гол асуудал нь төлбөрийн тэнцэл, ашиг ба орлогын урсгал болон зээл олголт байв. Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ нь бодлогын хүүг тогтвортой байлгах болон заавал байлгах нөөцийг бууруулах, репо зээл зэрэг арга хэмжээнүүд байв. 2019 оны IV улиралд бодлогын хүү 11% байсан бол үүнийг 6.0% хүртэл бууруулж, 2021 он дуустал бодлогын хүүг нэмээгүй бөгөөд энэхүү арга хэмжээ нь иргэд болон бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой байсан. Заавал байлгах нөөцийг бууруулах нь арилжааны банкнуудад зээл олгох эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилготой байсан. Эцэст нь репо санхүүжилтийн хөтөлбөрүүд нь зах зээлд илүү хөрвөх чадварыг бий болгож банкнуудад илүү их зээл олгох боломжийг олгосон. Эдгээр мөнгөний бодлого нь сүүлийн хоёр жилийн хугацаанд хэрэгжиж ирсэн бөгөөд гол төлөв цар тахлын сөрөг нөлөөг хэсэгчлэн бууруулахын тулд зарцуулалт болон эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэхэд чиглэсэн.


Банкнудын зээлийн үлдэгдэл

Арилжааны банкнудын зээлийн үлдэгдэл 2020 онд 5%-аар буураад байсан бол 2021 оны II улирлаас зээлийн үлдэгдэл өсөж эхэлсэн бөгөөд цар тахлын өмнөх үеийн зээлийн үлдэгдлийг давж, 2021 оны эцэст жилийн өсөлт нь 21.3%-д хүрч, нийт 20.7 их наяд төгрөгт хүрч байв. 2022 оны эхний улиралд зээлийн үлдэгдэл улам өсөж 21.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.2%-аар өсөв.

Салбаруудын зээлийн үлдэгдлийг дараах зурагт харуулав. 2021 оны зээлийн үлдэгдлийн өсөлтийн дийлэнх хэсгийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, боловсруулах, үл хөдлөх хөрөнгийн салбарын зээлийн өсөлт тайлбарлаж байна. Энэ нь 2021 оны I улирлаас 10 их наядын хөтөлбөрийг хэрэгжүүлж, ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээл, Ипотекийн зээл, Репо санхүүжилтийн зээлийг олгосонтой холбоотой байв.

Цар тахал үргэлжилж, банкны хүү буурахын хэрээр үл хөдлөх гэх мэт эрсдэл багатай хөрөнгүүдэд оруулах санхүүжилтийн өсөлт ажиглагдаж байна. Түүнчлэн Монголбанкны хэрэгжүүлж буй зээлийн хөтөлбөрүүд болон 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөөний хүрээнд уул уурхайн бус компаниудад зээл авахад илүү хялбар болсон. Нөгөөтээгүүр, хилийн хязгаарлалтаас үүдэн уул уурхайн компаниуд бүтээгдэхүүнээ экспортлох, барилгын компаниудад түүхий эдээ импортлоход хүндрэл учирсан. Эдгээр эрсдэлийн улмаас арилжааны банкнууд эдгээр салбарт их хэмжээний зээл өгөхөд өндөр эрсдэлтэй гэж үзсэн байх магадлалтай.


Зураг 12. Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл, салбараар, их наяд төгрөг



Эх сурвалж: Монголбанк

2020 онд эдийн засаг агшсанаар чанаргүй зээл болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь өсөж байсан. Харин 2021 оны II улирлаас энэхүү хувь хэмжээнүүд буурч эхэлсэн ба энэ нь зээлийн үлдэгдлийн өсөлттэй холбоотой байв. Мөн нөгөө талаас хэрэглээний зээл, ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулж, ангиллыг нь өөрчилж байсантай холбоотой. Эдийн засгийн идэвхжил бүрэн сэргэж амжаагүй байгаа энэ үед зээлийн хүү болон үндсэн зээлийн төлбөр зээлдэгчдэд дарамт болж байгаа тул 2021 онд олгогдсон их хэмжээний зээлийн зарим нь ирэх жилүүдэд чанаргүй болох магадлалтай байна.

Зураг 13. Арилжааны банкин дахь хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл, нийт зээлийн үлдэгдэлд эзлэх %




Эх сурвалж: Монголбанк

ЖДҮ болон иргэдийн зээл

2020 онд шинээр олгож байгаа ЖДҮ-гийн зээл харьцангуй тогтвортой байсан бол 10 их наядын хөтөлбөр хэрэгжсэнээр 2021 оны II улирлаас хойш хурдацтай өссөн. Ялангуяа 2021 оны II улиралд их шинээр олгосон ЖДҮ-гийн зээл 2020 оны II улиралтай харьцуулахад 1.5 дахин өсөж, 2.8 их наяд төгрөгт хүрч байв. 2021 онд нийтдээ 7.3 их наяд төгрөгийн ЖДҮ-ийн зээл олгосон ба 2020 онтой харьцуулахад 75.9%-аар өсжээ. Үүний 3.8 их наяд төгрөгийг ЖДҮ-эрхлэгч иргэдэд олгосон бол 3.5

их наяд төгрөгийг ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд олгосон байна. 2022 оны эхний улирлын байдлаар нийтдээ 1.2 их наяд төгрөгийн зээл олгоод байна.


Зураг 14. Шинээр олгосон ЖДҮ-ийн зээл, их наяд төгрөг



Эх сурвалж: Монголбанк

2021 онд ЖДҮ-д олгосон зээлийн бүтцийг доорх зурагт харуулав. Нийт зээлийн 34% нь бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчдэд, барилгын салбарт 7%, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 6%, хөдөө аж ахуйн салбарт 2%, үйлчилгээний салбарт 5% нь тус тус оногдож байна. Харин ЖДҮ-ийн зээлийн 46% нь бусад салбаруудад оногдож байна. 10 их наяд төгрөгийн хөтөлбөрөөр ЖДҮ-д олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлсэн нь энэхүү салбаруудад оногдох хувь хэмжээнд төдийлөн нөлөө үзүүлээгүй байна.

Зураг 15. 2021 онд олгогдсон ЖДҮ-ийн зээл, салбараар, %



Эх сурвалж: Монголбанк

Ипотекийн зээл

2020 онд шинээр олгосон ипотекийн зээлийн хэмжээ 2019 онтой ойролцоо түвшинд байсан бол 2021 онд ипотекийн зээлийг дэмжих бодлого хэрэгжсэнээр ипотекийн зээлийн хэмжээ огцом нэмэгдсэн. Тухайлбал, 2021 онд нийт 1.5 их наяд төгрөгийн ипотекийн зээл олгосон ба 2020 оноос 83.3%-аар өсжээ. 2022 оны эхний улиралд нийт 293 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосон бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15%-аар өссөн дүн юм.

Зураг 16. Шинээр олгосон ипотекийн зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголбанк

Ипотекийн зээлийг эх үүсвэрээр нь авч үзвэл, 2020 онд банк болон МИК-ийн эх үүсвэрийн зээлийн хэмжээ ойролцоо байсан бол 2021 онд МИК-ийн эх үүсвэрийн зээл 64.7%-ийг эзэлж байна. Гэхдээ, сүүлийн 2 улиралд банкны эх үүсвэрээс олгож байгаа ипотекийн зээлийн хэмжээ нэмэгдэж байна.

Орон сууцны өртөг болон үнэ 2020 онд тогтвортой бага түвшинд байсан бол 2021 оны II улирлаас огцом нэмэгдсэн. Энэ нь эрэлт талаас 10 их наядын хөтөлбөр хэрэгжиж, ипотекийн зээлийг их хэмжээгээр нэмэгдүүлсэнтэй холбоотой. Нийлүүлэлт талаас Хятад Улсаас хилээр нэвтрэх бараа бүтээгдэхүүний хэмжээг хязгаарласан, тээврийн үйлчилгээний үнэ нэмэгдсэн болон барилгын материалын үнэ өссөн зэрэгтэй холбоотой байв. 2022 оны эхний улирлын байдлаар орон сууцны өртгийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.9%, орон сууцны үнийн индекс 20.4% тус тус өсжээ.

Зураг 17. Орон сууцны өртөг ба үнийн индекс



Эх сурвалж: YCX, Монголбанк, Тэнхлэг зууч ХХК

2. Эдийн засгийг эрчимжүүлэх 10 их наядын бодлогын хэрэгжилт ба үр нөлөө

2.1. Бодлогын хэрэгжилт

Өмнө дурдсанчлан цар тахлын улмаас улс орны эдийн засаг 2020 онд 4.6 хувиар агшиж, төсвийн алдагдал ДНБ-ий 12 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн. 2022 оны 1-р сарын 4-ний УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралд Сангийн дэд сайдын мэдээлснээр, 2021 оны эхээр зах зээлийн тодорхойгүй байдлын улмаас банкнуудын олгох зээлийн хэмжээ буурч, банкнуудын нийт 8 их наяд төгрөгийн эх үүсвэр Төв банкны үнэт цаасанд байршаад байсан. Түүнчлэн 2020 онд нийт 65,000 гаруй ажлын байр алдагдаж, цаашид эдийн засгийг сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй тохиолдолд 130,000 гаруй ажлын байр алдах эрсдэл үүссэн байсан нь эдийн засгийг эрчимжүүлэх 10 их наядын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэг үндэслэл болж байв.

Засгийн газраас хэрэгжүүлж буй "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний эдийн засгийн хөтөлбөрүүдийг Засгийн газар дараах 4 чиглэлд нэгтгэн хэрэгжилтийг нь олон нийтэд мэдээлж байсан. Үүнд:

1. Ажлын байрыг дэмжих (2 наяд төгрөг)
2. Монголбанкны репо санхүүжилт (2 наяд төгрөг)
3. Ипотекийн зээл (2 наяд төгрөг)
4. Хөдөө аж ахуйн зээл (500 тэрбум төгрөг)

Эдгээр зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тус бүрээр нь авч үзье.

Ажлын байрыг дэмжих 2 их наядын зээлийн хэрэгжилт

Энэхүү зээлийг НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлсэн, эсвэл НӨАТ-аас чөлөөлөгдсөн, банкнаас зээлийн үйл ажиллагааны журам, зааврын хүрээнд тавигдсан бусад шаардлагыг хангасан, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага болон банкнаас зээлийн үйл ажиллагааны журам, зааврын хүрээнд тавигдсан шаардлагыг хангасан хувиараа үйлдвэр, үйлчилгээ, худалдаа эрхлэгч иргэнд нийт 3 жилийн хугацаатай, 3.0 хувийн хүүтэй, нэг жилийн хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй олгож байна. Нийт олгох зээлийн 50.0 хүртэл хувийг ижил зориулалттай олгогдсон зээлийн дахин санхүүжилтэд ашиглаж болно. Ажлын байрыг дэмжих хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагад олгох зээл 500.0 сая төгрөг хүртэл, иргэнд олгох зээл 50.0 сая төгрөг хүртэл хэмжээтэй байх ба Засгийн газраас аж ахуйн нэгжид олгосон зээлийн нийт хүүгийн 6.0 нэгж хувийг, иргэнд олгосон зээлийн нийт хүүгийн 7.0 нэгж хувийг хариуцан төлж дэмжлэг үзүүлэхээр заасан.

10 их наядын хөтөлбөрөөс хамгийн өргөн хүрээг хамарсан зээлийн үйл ажиллагаа нь Ажлын байрыг дэмжих 2 их наядын зээл байсан. Сангийн яамны 2021 оны 8-р сарын мэдээллээр, уг зээл олголт эхэлсэн эхний 3 сард нийт 6.3 их наяд төгрөгийн 60.7 мянган хүсэлт ирснээс 1.7 их наяд төгрөгийн зээлийг 22.7 мянган зээлдэгчид олгожээ (Зураг 18).

Зураг 18. Ажлын байрыг дэмжих 2 их наядын зээлийн хэрэгжилт, 2021 оны 8-р сар




Эх сурвалж: Сангийн яам (Сангийн яам, 2021a)

Зээл олголт эхэлсэн эхний 3 сарын байдлаар зээл авч чадсан ба татгалзсан хүсэлтийн харьцаа 4 байгаа нь хүсэлт гаргагчид банкны тавьж буй шаардлагыг сайн хангаж байгааг харуулж байна. Судалгаанд байгаа болон судалгаанд ороогүй хүсэлтийн тоог харвал зээл олголтын хэмжээ богино хугацаанд 2 их наяд төгрөгийн төлөвлөсөн дүнд хүрсэн байхаар харагдаж байна. Уг зээлд хамрагдсан бизнес эрхлэгчдийн төлөөлөлтэй ярилцахад, зээлийн хүсэлтээ зээл олголт эхэлсэн 3-р сард гаргасан ба хүсэлт гаргаснаас хойш 20-30 хоногт багтаан зээл авч чадсан байна.


2022 оны 1-р сарын 4-ний УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралд Монголбанкны өгсөн мэдээллээр, уг зээлийг олгох үйл ажиллагаанд арилжааны 12 банк оролцсон бөгөөд 1 их наяд 952 тэрбум төгрөгийн зээлийг олгож, зорилт үндсэндээ биелжээ. Үүнээс 1.6 их наяд төгрөгийн зээлийг шинээр олгосон бол 4317 зээлдэгчийн 271 тэрбум төгрөгийн зээлийг дахиж санхүүжүүлсэн байна. Зээл олголт эхэлснээс хойш улсын төсвөөс 67 тэрбум төгрөгийн хүүний татаасыг банкуудад шилжүүлсэн байна.

Зураг 19. Ажлын байр дэмжих зээл олголтын хэрэгжилт, 2021 оны 12-р сарын 31.



Ажлын байрыг дэмжих зээлийн хөтөлбөрөөр нийт 25,514 зээлдэгчид зээл олгож 109,763 ажлын байр хадгалж чадсан гэж Монголбанк тооцож байна. Доорх зурагт уг хөтөлбөрөөр хадгалсан ажлын байр ба олгосон зээлийн хэмжээг харьцуулан харуулав.

Зураг 20. Хадгалсан ажлын байрны тоо ба олгосон зээлийн тоо, зээлдэгчээр



Зээлийн хүсэлт гаргаад зээл авч чадаагүй аж ахуйн нэгжийн төлөөллийн ярьснаар, барьцаа хөрөнгийн шаардлага хангаагүй, эргэлтийн хөрөнгийн биш хөрөнгө оруулалтын зээл хүссэн зэрэг нь зээл авч чадаагүй гол шалтгаан болжээ.

Зарим бизнес эрхлэгчдийн мэдээлж буйгаар, анх хүссэн зээлийн 50 орчим хувьтай тэнцэх зээл гарч байв. Энэ нь голчлон барьцаа хөрөнгийн үнэлгээ бага байсантай холбоотой байжээ.

Нийт зээлдэгчдийн дөнгөж 1 хувь буюу 208 зээлдэгч Зээлийн батлан даалтын сангаас 28 тэрбум төгрөгийн зээлийн баталгаа гаргуулжээ. Эндээс зээл хүсэгчид ерөнхийдөө арилжааны банкуудын тавьсан шаардлагыг хангаж байгаа бөгөөд ЗБДС-аас баталгаа гаргуулах хэрэгцээ бага байсан гэж дүгнэх хэцүү. Учир нь уг сангийн талаар ямар нэг мэдээлэлгүй байсан, уг сангийн үйлчилгээг хэрхэн авах талаар судлаагүй, мэдэхгүй байх тохиолдол их байжээ. Гэхдээ хөнгөлөлттэй зээл олгож буй арилжааны банкны мэдээлснээр, Зээлийн батлан даалтын санд хандахыг харилцагчдад санал болгож байсан. Мөн зээлийн батлан даалтын сангийн зээлийн судалгаа 5 хоногт шийдвэрлэгддэг тул банкны зүгээс бэрхшээл багатай гэжээ.

Зээлд хамрагдсан зарим ЖДБ-ийн төлөөлөлтэй ярилцахад, ерөнхийдөө уг зээл аж ахуйн нэгжүүдэд чухал дэмжлэг болж чадсан гэж дүгнэж байна. Зээлдэгчид зээл олгохоос өмнө ба олгосны дараа банкны ажилтнууд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьж байсныг зарим бизнес эрхлэгч дурдаж байв. Мөн арилжааны банкны өгсөн мэдээллээс харахад зээлийн зориулалт, ашиглалт, эргэн төлөлтөд зээл олгосноос хойш улирал бүр газар дээрх хяналтыг, сар тутам зайны хяналтыг тавьж, хяналтын тайланг баталгаажуулж ажиллаж байгаа аж.

Байгуулагдаад удаагүй, шинэ бизнесүүдэд зээлийн шаардлагыг бууруулах, хот хөдөөгийн бизнесүүдэд онцлогт тохирсон ялгаатай шаардлага тавих, худалдаа гэхээсээ дотоодын үйлдвэрлэл, тэр дундаа малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, зээлийг түүхий эд бэлтгэх, боловсруулах гэх мэт нэмүү өртгийн сүлжээг багцаар хамарсан байдлаар олговол үр дүнтэй гэх мэт саналыг дэвшүүлж байв.

Нөгөө талаас, зээл олголтыг хэрэгжүүлсэн арилжааны банкнуудын байр суурийг энд тодруулах шаардлагатай. Богино хугацаанд их хэмжээний зээлийн хүсэлт хүлээн авч судлан зээл олгох нь банкнуудын ажлын ачааллыг ихээр нэмэгдүүлж байжээ. Сангийн яамны мэдээллээс харахад, ажлын байрыг дэмжих зээлийн 44%-ийг Хаан банк, 21%-ийг Төрийн банк олгож гол ачааллыг үүрчээ. Энэ хөтөлбөр эхлэхээс өмнө ч цар тахлын эсрэг бусад хөтөлбөр, арга хэмжээний улмаас банкнуудын ажлын ачаалал их байсан. Энэ нь нөгөө талаас зээлийн хүсэлт бүрийг нарийвчлан судлах боломжийг хязгаарлаж, зөвхөн тавьсан шаардлагуудыг хангуулахад анхаарах, барьцаа хөрөнгө багатай аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, зээлээ эргүүлэн төлөх боломж, давуу талуудыг тодорхойлох нэмэлт үйл ажиллагааг банкны зүгээс хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байжээ.

Ажлын байрыг дэмжих зээл нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд 3 хувийн хүүтэйгээр очих боловч төсвөөс санхүүжүүлэх хүүгийн татаасыг оролцуулаад банкны хувьд 9 хувийн хүүтэй зээл юм. Гэтэл бизнесийн зээлийн хүү үүнээс өндөр байсан. Иймээс хөнгөлөлттэй зээл олгох нь банкнуудын хувьд алдагдалтай байх талаар Монголын Банкны холбоо зээл олголт эхэлсэн 2021 оны 3-р сард мэдээлж байв. Тухайлбал, Ажлын байрыг дэмжих 3 хувийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр банкнууд 0.8-2.4 нэгж хувийн хүүгийн алдагдал хүлээх болсон (Зураг 21).

Зураг 21. Ажлын байрыг дэмжих зээлээс хүлээх алдагдал



Эх сурвалж: Монголын Банкны Холбоо, (Монголын Банкны Холбоо, 2021)

Мөн банкнуудын үйл ажиллагааны хувьд зээлийн хүсэлтийн огцом нэмэгдэж, ачаалал өсөх, үүнээс шалтгаалаад зардал өсөх нөлөө үзүүлжээ. Тухайлбал, 2021 оны 6-р сард “Хөгжлийн шийдэл” ТББ-ын зохион байгуулсан “Гурван хувийн хүүтэй зээл бодит эзэндээ хүч чадаж байна уу?” хэлэлцүүлэгт оролцсон банкнуудын төлөөлөл “Зээлийн ажилтнуудад хөнгөлөлттэй зээлийн талаар нэмэлт сургалт явуулсан. Мөн зээлийн ажилчдын ачаалал 400 хувь нэмэгдсэн” гэж мэдээлжээ. Үүнээс гадна зээл хүсэж буй иргэд ААН-ээс шалтгаалан зээлийн судалгааны явцад хүндрэл учрах тохиолдол багагүй байдаг талаар дурдаж байв. Энэ талаар “Хөнгөлөлттэй зээл хүсэгчид зээлийн хэмжээгээ 500 сая төгрөг эсвэл 50 сая төгрөгт тулгаж хүсэлт гаргадаг, яг хэдэн төгрөгийн зээл хэрэгтэй талаараа сайн тооцоогүй байна. Бодит байдал дээр ийм хэмжээний зээл шаардлагагүй байх тохиолдлууд их гардаг. Энэ нь зээлийн судалгаанд ихээхэн хүндрэл учруулж байна” гэжээ.

Монголбанкны репо санхүүжилт болон ипотекийн зээлийн хэрэгжилт

Монголбанкны репо зээлийн хөтөлбөр нь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагаа бөгөөд эдийн засгаа сэргээх 10 их наядын бодлого зарлахаас өмнө хэрэгжиж эхлээд байсан. Сангийн яамны мэдээлснээр, 2021 оны эхний 8 сард уг зээлд 2645 зээлдэгч хамрагдаж, нийт 593 тэрбум төгрөгийн зээл олгожээ (Зураг 22)


Зураг 22. Монголбанкны репо санхүүжилтийн 2 их наядын зээлийн хэрэгжилт, 2021 оны 8-р сар



Эх сурвалж: Сангийн яам (Сангийн яам, 2021a)

Дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийг 2021 оны эцсээр дүгнэвэл зээлдэгчийн тоо ба хадгалсан ажлын байрны тоо 30 орчим хувь нэмэгджээ.

Зураг 23. ААН, иргэдэд олгосон репо санхүүжилт, 2021 оны 12-р сарын 31



Энэ хөтөлбөрт 2021 оны эцсийн байдлаар нийт 3395 зээлдэгч хамрагдсаны 1814 нь иргэд, 1581 нь ААН байжээ. Эдгээр зээлдэгч нийт 36,622 ажлын байр хадгалснаас ААН-үүд 32,791, иргэд 3,831 ажлын байр хадгалжээ.

Ипотекийн зээлийн хөтөлбөр нь орон сууцны бүтээн байгуулалтыг давтан хэрэглэх нэг маягийн зураг, газар олголт, дэд бүтцийн бүтээн байгуулалт, ипотекийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр болон төр, хувийн хэвшлийн зохистой түншлэлийн хүрээнд дэмжиж, иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн, инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцаар хангах үйл ажиллагааг дэмжих зээл юм. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн дунд хугацааны эрэлтийг харгалзан, ипотекийн

6.0 хувийн хүүтэй зээлийн эх үүсвэрийг жилийн 1.0 их наяд төгрөгт хүргэж, 14,000 өрхийг зээлд хамруулах зорилттой.

Тус бодлогын хэрэгжилтийн явцын талаарх Сангийн яамны мэдээллийг доорх зурагт харуулав. 2021 оны эхний 8 сарын байдлаар 6917 зээлдэгчид 512.9 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Зураг 24. Ипотекийн 2 их наядын зээлийн хэрэгжилт, 2021 оны 8-р сар



Эх сурвалж: Сангийн яам (Сангийн яам, 2021a)

Харин 2021 оны эцэс гэхэд уг хөтөлбөрөөс 12,223 зээлдэгчид 955,7 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Мөн 10 их наядын санхүүжилтээс гадна урьд нь хэрэгжиж байсан ипотекийн хөнгөлөлттэй санхүүжилт болон банкны өөрийн эх үүсвэрийн санхүүжилтийг нэмж тооцвол 2021 онд нийт 1,554.1 тэрбум төгрөг орон сууцны ипотекийн зээлд олгогджээ. Энэ нь 8%-ийн ипотекийн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн 2013 оны түвшин (1,789.1 тэрбум)-д дөхөж очих өндөр үзүүлэлт юм.

Хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хэрэгжилт

Энэ зээл нь 2021 болон 2022 онд хэрэгжих хуваарьтай. Хөдөө аж ахуйг 2021 онд дэмжих зээл нь тус салбарын хаврын тариалалтад 40.0 тэрбум төгрөг, ноолуур бэлтгэлийн үйл ажиллагаанд 110 тэрбум төгрөгийг, аймаг, нийслэлийн хүн амын 2021-2022 оны өвөл, хаврын улирлын хүнсний хэрэгцээнд 20 мянган тонн хүртэл махны нөөц бүрдүүлэхэд зориулан 100 тэрбум төгрөгийг, 2021 оны намрын ургацаас гурил, тэжээлийн үйлдвэрт улаан буудай, дотоодын үйлдвэрт тосны ургамал худалдан авахад зориулан 150 тэрбум төгрөгийг тус тус 1 жилийн хугацаатай 3.0 хувийн хүүтэй олгох зээл юм. Засгийн газраас нийт зээлийн хүүгийн 7.65 нэгж хувийн хүүгийн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөсөн.

Харин ХАА-г 2022 онд дэмжих зээл нь ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлд 150 тэрбум төгрөгийг 2 жилийн хугацаатай, газар тариалангийн үйлдвэрлэлд 100 тэрбум төгрөгийг 2 жилийн хугацаатай, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд 50 тэрбум төгрөгийг 2 жилийн хугацаатай, ноос бэлтгэл, үйлдвэрлэлд 25 тэрбум төгрөгийг 2 жилийн хугацаатай, арьс, шир бэлтгэл, үйлдвэрлэлд 15 тэрбум төгрөгийг 2 жилийн хугацаатай, гурил, тэжээл, ургамлын тосны үйлдвэрлэлд 40 тэрбум төгрөгийг 1 жилийн хугацаатай олгох зээл юм. Уг зээлийн хүү 3.0 хувь байх бөгөөд Засгийн газраас нийт зээлийн хүүгийн 10.65 нэгж хувийн хүүгийн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөсөн.

Мөн дээрх зээлд малчдыг дэмжсэн зээл нэмэгдэх бөгөөд 200 тэрбум төгрөгийг 3 жилийн хугацаатай 3 хувийн хүүтэй банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан олгохоор төлөвлөсөн. Үүнд Засгийн газраас нийт зээлийн хүүгийн 7 нэгж хувийг хариуцан төлж дэмжлэг үзүүлэх юм.

Хөдөө аж ахуйг дэмжих чиглэлээр 2021 онд 500 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс 494 тэрбум төгрөгийн буюу 98 хувийн гүйцэтгэлтэй байжээ. Зээл олголтын гол асуудлыг салбарын яам хариуцсан, арилжааны банкуудтай гэрээ хийх байдлаар олгосон. Зээлийн эрсдэлийг арилжааны банкууд даах тул банкны шаардлагын дагуу зээлийг олгосон бөгөөд төрийн зохицуулалтаар нэг ч төгрөгийн зээл олгоогүй, 100 хувь банкны системээр дамжсан гэж Сангийн яам мэдээлжээ.

2021 оны 8-р сарын байдлаар уг зээлийн хөтөлбөрт нийт 19,737 зээлдэгч хамрагдаж 309.2 тэрбум төгрөгийн зээл олгогдоод байжээ (Зураг 25). Зээл олгосон гол банкууд нь Хаан банк (58.5%), Төрийн банк (35.9%) байсан. Банкнудын мэдээлснээр ХАА-г дэмжих зээлд хамрагдаж чадахгүй байгаа гол шалтгаан нь НӨАТ төлөгчөөр бүртгэлтэй байх шаардлагатай холбоотой бол малчдын хувьд өмнөх зээлийн үлдэгдэл их буюу өр орлогын харьцааг хангахгүй байжээ.

Зураг 25. Хөдөө аж ахуйг дэмжих 500 тэрбумын зээлийн хэрэгжилт, 2021 оны 8-р сар



Эх сурвалж: Сангийн яам (Сангийн яам, 2021a)

Харин 2021 оны эцсийн байдлаар ХАА-н зээл олголт 494.3 тэрбум төгрөг хүрч зорилтдоо бараг хүрчээ. Энэ хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. ХАА-н зээл олголт, тэрбум төгрөг, зориулалтаар (2021-12-31)

Зээлийн төрөл	Зээлийн хэмжээ	Хувь	Зээлдэгчийн тоо
Малчдыг дэмжих зээл	199.6	40%	19,870
Махны нөөц бүрдүүлэх зээл	97.6	20%	46
Ноолуур бэлтгэлийн зээл	94.9	19%	38
Хаврын тариалалтын зээл	43.3	9%	629
Улаан буудай, тосны ургамал худалдан авах	42.4	9%	11
Арьс шир бэлтгэлийн зээл	13.2	3%	9
Ноос бэлтгэлийн зээл	3.2	1%	4
Хөдөө аж ахуйн зээл нийт	494.3	100%	20,607

Эх сурвалж: Монголбанк


Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч арилжааны банкны өгсөн мэдээллээр, 2022 оны I улирлын эцсийн байдлаар нийт хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт хэвийн байсан. Гэхдээ дээрх зээлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаарх сүүлийн үеийн дэлгэрэнгүй мэдээлэл хомс, хэрэгжилт хэрхэн явагдсан, ямар бэрхшээл хүндрэл бэрхшээл тулгарч байсан талаарх Засгийн газрын болон хэрэгжүүлэгч байгууллагуудын тайлан мэдээлэл хомс байна. Гэвч 10 их наядын цогц төлөвлөгөөний үр дүн, үр нөлөөний талаар зарим хөндлөнгийн судалгааны байгууллага, судлаачид үнэлгээ, дүгнэлт дэвшүүлснийг дараагийн хэсэгт авч үзье.

2.2. Бодлогын үр нөлөө


10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд 2021 онд нийтдээ 4.3 их наяд төгрөг зарцуулжээ. Гэтэл 2020 онд 4.6 хувиар буураад байсан эдийн засаг 2021 онд дөнгөж 1.4 хувь өсөж, эдийн засгийн сэргэлт маш сул байв. Гэхдээ нөгөө талд 2021 онд хил гаалийн хязгаарлалт, малын гоц халдварт өвчин зэрэг гадаад дотоод шокуудын улмаас аж үйлдвэр, уул уурхай, хөдөө аж ахуйн салбаруудад хүндрэл учирсан. Тиймээс тус бодлого хэр амжилттай хэрэгжиж байгааг шууд тодорхойлоход хүндрэлтэй. Бид энэ хэсэгт Сангийн яам, олон улсын байгууллагуудын эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний талаар хийсэн дүгнэлт болон судлаачдын тус хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаануудыг тоймлон авч үзье.

Сангийн яамны үзэж байгаагаар 10 их наядын цогц төлөвлөгөө нь эдийн засаг болон зээлийн өсөлтөд маш хүчтэй эерэг нөлөөг үзүүлжээ. Энэхүү цогц төлөвлөгөөний хүрээнд эдийн засгаа сэргээх чиглэлээр 1) ажлын байрыг дэмжих зээл, 2) репо санхүүжилтийн зээл, 3) ипотекийн зээл, 4) хөдөө аж ахуйн зэрэг зээлийн сувгаар зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлсээр банкны секторын зээл 2021 оны эхний хагасын байдлаар 10.5 хувиар агших байсныг 6.5 хувийн өсөлттэй гарахад нөлөөлжээ (Сангийн яам, 2021b).

Зураг 26. Банкны зээлийн үлдэгдэл, их наяд төгрөг



Зураг 27. 10 их наядын эдийн засгийн өсөлтөд үзүүлсэн нөлөө



Эх сурвалж: Сангийн яам (2021b) Монгол Улсын нэгдсэн төсөв 2022


Сангийн яам 2021 оны 9-р сарын байдлаар 2021 онд эдийн засгийн өсөлт 6.9 хувьд хүрнэ гэж таамаглаж байсан бөгөөд хэрвээ тус хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй бол эдийн засгийн өсөлт 1.6 хувь, мөн тус хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй болон иргэдийг Ковид-19-ийн эсрэг вакцинд хамруулаагүй

бол эдийн засгийн өсөлт -2.4 хувь хүрнэ гэж тооцоолж байжээ (Зураг 27). Өөрөөр хэлбэл, тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2021 эдийн засгийн өсөлтийг 9.3 нэгж хувиар нэмэгдүүлж чадсан гэж тооцоолжээ. Гэхдээ энэхүү симуляц тооцооллыг хийсэн аргачлалын талаар тодорхой дурдаагүй байна.

10 их наядын цогц төлөвлөгөөний 2 их наяд төгрөгийн зээлийг цар тахлын үед ажлын байрыг авч үлдэх зорилгоор аж ахуй нэгж, хувь хүмүүст олгосон. Сангийн яамны мэдээлж байгаагаар 2021 оны 9 дүгээр сарын 28-ны байдлаар нийт 58,122 зээлдэгчид 3771.2 тэрбум төгрөгийн зээлийг банкнуудын эх үүсвэрээр олгож, 10,401 иргэнийг орон сууцжуулж, 267,743 ажлын байрыг хадгалсан үзүүлэлтэй байна (Сангийн яам, 2021b).


Гэхдээ Сангийн яам энэхүү тооцооллыг хийхдээ хөнгөлөлттэй зээлийг олгоогүй бол байсан бол аж ахуйн нэгжүүд бүх ажилчдаа хална гэсэн таамаглал дээр суурилжээ. Түүнчлэн, хөнгөлөлттэй ипотекийн зээл нь барилгын салбарын бүх ажил эрхлэлтийг хадгалсан гэж үзжээ. Харин Дэлхийн Банкны хийсэн тооцооллоор 2021 онд 168,000-230,000 ажлын байрыг хадгалсан байх магадлалтай гэсэн дүгнэлтэд хүрчээ (Зураг 29). Тэд энэхүү тооцооллыг хийхдээ энгийн симуляц аргачлалуудыг ашигласан бөгөөд улирлын шинж чанартай хөдөлмөр эрхлэлтийг тооцсон болон тооцоогүй гэсэн хоёр хувилбартай хийжээ. Улирлын шинжтэй ажлын байргыг харгалзаагүй тохиолдолд 170,000-281,000, харин улирлын шинжтэй ажлын байрыг харгалзан үзсэн тохиолдолд 168,000-230,000 ажлын байрыг хамгаалсан гэсэн дүгнэлтэд хүрчээ (Дэлхийн Банк, 2022).

Зураг 28. Ажил эрхлэлтийн тоо, Сангийн яамны тооцоолол, мянган хүн, 2021 оны 9-р сарын байдлаар



I	II	III	IV	I	II
2020				2021	

Зураг 29. Ажил эрхлэлтийн тоо, Дэлхийн Банкны тооцоолол, улирлын шинж чанартай ажлын байрыг харгалзсан




III	IV	I	II	III	IV
2020		2021			

Эх сурвалж: Сангийн яам (2021) Монгол Улсын нэгдсэн төсөв 2022, Дэлхийн банк (2022), Монгол Улсын эдийн засгийн тойм: Шуурган дунд зүг чигээ олохуй


Хэдийгээр 10 их наядын цогц төлөвлөгөө нь ажлын байрыг их хэмжээгээр хадгалж чадсан ч Дэлхийн Банкны дүгнэснээр инфляцыг нэмэгдүүлэх нэг шалтгаан болжээ. Тодруулбал 2021 оны эхний хагаст мөнгөний нийлүүлэлтийг гадаад цэвэр актив (ГЦА) дэмжиж байсан бол 10 их наядын цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлснээр энэхүү хандлага өөрчлөгдөн, 2021 оны 2-р хагасаас дотоод цэвэр зээл (ДЦЗ)-ийн мөнгөний нийлүүлэлтэд үзүүлэх нөлөө эрс нэмэгдэж эхэлсэн байна (Зураг 30). Цаашлаад энэхүү хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсвийн шинж чанартай арга хэмжээ нь

Зураг 30. М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал



Судалгааны үр дүнгээс харахад, 2.2 их наядын хөнгөлөлттэй зээл нь оны үнээрх нэмүү өртгийг 5.9 хувиар өсгөх хэмжээний дэмжлэг үзүүлж, 81.8 мянган ажлын байрыг хадгалах боломжийг бүрдүүлжээ. Салбараар нь харвал хөдөө аж ахуйн салбарын өсөлтөд 7.8 хувийн дэмжлэг үзүүлж, 14.3 мянган ажлын байрыг хадгалах, үйлдвэрийн салбарын өсөлтөд 2.0 хувийн дэмжлэг үзүүлж, 2.7 мянган ажлын байрыг хадгалах, үйлчилгээний салбарын өсөлтөд 10.2 хувийн дэмжлэг үзүүлж, 64.8 мянган ажлын байрыг хадгалах боломж бүрдүүлжээ (Зураг 31).

Зураг 31. 3 хувийн хөнгөлөлттэй зээлийн өсөлт дэмжсэн хувь ба хадгалсан ажлын байрны тоо



Эх сурвалж: Б.Уранбилэг (2022)

10 их наядын цогц төлөвлөгөөний эдийн засагт үзүүлэх нөлөөг Монголбанк нэлээд олон үзүүлэлтээр нарийвчлан хэмжжээ.

Тухайлбал, тус цогц төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн зээл олголтын нийт зээлд үзүүлэх нөлөөг авч үзье. Доорх зурагт харуулснаар хэрэв цогц төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй бол нийт зээлийн үлдэгдэл 2.7%-р буурч, одоогийн зээлийн үлдэгдлийн 80%-тай тэнцэх байв.



Зураг 32. 10 их наядын зээлийн хөтөлбөрүүдийн нийт зээлд үзүүлсэн нөлөө



Эх сурвалж: Монголбанк

Дээрх нөлөөг салбараар тодруулж авч үзвэл, зээлийн зориулалттай шууд холбоотойгоор уул уурхайн бус салбар болон ЖДҮ салбарын зээл нэмэгдэхэд 10 их наядын цогц төлөвлөгөө гол нөлөө үзүүлжээ.

Зураг 33. 10 их наядын зээлийн хөтөлбөрүүдийн салбаруудын зээлд үзүүлсэн нөлөө




Эх сурвалж: Монголбанк

Дээрх хөнгөлөлттэй зээл олгох хугацаанд нийт мөнгөний нийлүүлэлт 2.8 их наяд төгрөгөөр нэмэгджээ. Мөн зээлийн дундаж хүү эрс буурсан байна. Зээлийн хүү бууруулах стратегийн хүрээнд хүүний түвшин ерөнхийдөө буурах хандлагатай байсан бол цогц төлөвлөгөөний хэрэгжилт хүүг богино хугацаанд хүчтэй бууруулжээ.

Зураг 34. M2 Мөнгөний нийлүүлэлт



Зураг 35 Хүүний түвшин



Эх сурвалж: (Монголбанк, 2022)

Дээрх судалгаануудад эдийн засгийг сэргээх 10 их наядын хөтөлбөрийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөг хэмжсэн. Гэхдээ олон улсын байгууллагуудын үзэж байгаагаар эдийн засгаа сэргээхийн тулд эдийн засгийн гол тулгуур болдог жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжсэн бодлогуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. ЖДҮ нь Монгол Улсын бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 77 хувь, ажиллах хүчний 72 хувь, ДНБ-ий 17.8 хувь, экспортын 2.3%-ийг бүрдүүлдэг (ADB, 2020). Тиймээс тус хөтөлбөрийн жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдэд хэр үр дүнтэй нөлөөлж байгааг судлах нь маш чухал. Монголын эдийн засгийн шинжилгээ судалгааны төв (MEARC) (2022) ЖДҮ эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл, ялангуяа бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хүндрэл, хэрэгцээг тодорхойлох, тэдэнд ямар санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх боломжтойг



тодорхойлохыг зорьжээ. Тус судалгааныхаа хүрээнд Ковид-19 цар тахлын үед засгийн газрын авч хэрэгжүүлж байгаа бодлогууд хэр үр дүнтэй байгааг мөн тодруулжээ. Судалгааны үр дүнгээс харахад тус хөтөлбөр ЖДҮ эрхлэгчдэд хангалттай сайн нөлөө үзүүлээгүй байна.

Тэд судалгааны мэдээллээ 2022 оны 1 сарын 12-ноос 31-ний хооронд цуглуулсан бөгөөд 7 дүүрэг 21 аймгийн нийт 1000 ЖДҮ эрхлэгчдийг хамруулжээ (Улаанбаатараас 59.6%, орон нутгаас 40.4%). Засгийн газраас хэрэгжүүлсэн эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгийг сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж байгаа ЖДҮ-д эерэг нөлөө үзүүлж болох 9 арга хэмжээг сонгон авчээ:

1. Ажлын байр дэмжих зээл
2. Ипотекийн зээл
3. Хөдөө аж ахуйг дэмжих зээл
4. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгох
5. Дотоодын үйлдвэрлэл, ногоон худалдан авалтыг төрийн худалдан авалтаар дэмжих
6. Аж ахуй нэгжүүдэд хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэх
7. Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг 50 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргах, батлан даалтын үүрэг гүйцэтгэх хугацааг богино болгох
8. Цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, хог хаягдлын төлбөр хураамжийг төрөөс хариуцах
9. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх хуулийг хэрэгжүүлэх

Тус судалгааны үр дүн өмнө дурдсан макро түвшний судалгааны үр дүнгүүдээс нэлээд ялгаатай байна. Тухайлбал, нийт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 70 гаруй хувь нь 3 хувийн хүүтэй ажлын байрыг дэмжих зээл нь ямар ч нөлөөгүй эсвэл ямар нөлөөтэй байсныг нь мэдэхгүй гэж хариулжээ. Харин 20.2 хувь нь л маш сайн болон сайн нөлөөтэй байсан гэж дүгнэжээ (Зураг 36). Түүнчлэн тус хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа 6 хувийн хүүтэй ипотекийн зээл нь ЖДҮ-ийн салбарт төдийлөн нөлөөгүй байсан ба нийт судалгаанд оролцогчдын 79.5 хувь нь ямар нэг нөлөө үзүүлээгүй гэж хариулжээ (Зураг 37). Цаашлаад түүвэрт 89 барилгын компани хамрагдсан бөгөөд тэдний 92 хувь нь ипотекийн хөтөлбөр ямар нэгэн нөлөөгүй байсан эсвэл нөлөөг нь мэдэхгүй байна гэж хариулсан байна.

Зураг 36. Ажлын байрыг дэмжих зээлийн нөлөө **Зураг 37. Ипотекийн зээлийн нөлөө**




Эх сурвалж: MEARC (2022)


Түүнчлэн ипотекийн зээлийн шууд бус нөлөө нь орон сууцны үнийн хөөргөдөл үүсгэх эрсдэлийг агуулж байгаа бөгөөд энэ нь сүүлийн үеийн орон сууцны үнийн өсөлтөөс харагдаж байна. Орон сууцны үнэ 2022 оны I улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 30.9 хувиар нэмэгджээ (Зураг 17).

Хөдөө аж ахуйг дэмжих 500 тэрбум төгрөгийн зээл ч ЖДҮ эрхлэгчдэд нөлөө бараг үзүүлээгүй байна. Нийт түүвэрт багтсан жижиг дунд үйлдвэрлэгчдийн ердөө 2.4 хувь нь л сайн, маш сайн нөлөөтэй байсан гэж үнэлсэн бол 81.3 хувь нь ямар ч нөлөөгүй байсан гэж хариулжээ (Зураг 38). Цаашлаад тухайн түүвэр судалгаанд ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулдаг 89 ЖДҮ эрхлэгч хамрагдсан бөгөөд ердөө 10 хувь нь л тус зээлийг авч чаджээ. Цаашлаад 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөр байгаа бөгөөд энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 онд нийтдээ 1000 гаруй иргэн, ААН-д хөнгөлөлттэй зээл олгохоор төлөвлөсөн. Гэвч судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ердөө 7.1 хувь нь тус хөтөлбөрийг сайн, маш сайн гэж үнэлсэн бол 85.8 хувь нь нөлөө байгаагүй эсвэл нөлөөг нь мэдэхгүй хэмээн хариулжээ (Зураг 39).

Зураг 38. ХАА-г дэмжих зээлийн нөлөө



Зураг 39. ЖДҮ, бичил үйлдвэрлэлийг дэмжих зээл




Эх сурвалж: MEARC (2022)


Дотоодын үйлдвэрлэл, ногоон худалдан авалтыг төрийн худалдан авалтаар дэмжих, аж ахуйн нэгжүүдэд хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэх болон Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зэрэг бодлогууд нь дээрх бодлогуудын үр дүнтэй адилаар нөлөө байгаагүй гэсэн хариулт давамгайлж байна. Гэхдээ эдгээр бодлогууд дундаас хамгийн үр дүнтэй байсан нь аж ахуй нэгжүүдийн цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, хог хаягдлын төлбөр хураамжийг төрөөс хариуцсан арга хэмжээ байжээ. Тодруулбал, судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 35.4 хувь нь уг арга хэмжээг маш сайн, 31.9 хувь нь сайн 25 хувь нь нөлөө байгаагүй хэмжээн дүгнэжээ (Зураг 40). Түүнчлэн, ЖДҮ-дэд дараагийн эерэг нөлөө үзүүлсэн бодлого нь аж ахуйн нэгж болон ажиллагсдыг нийгмийн даатгалын шимтгэлээс түр хугацаанд чөлөөлсөн бодлого байжээ. Тухайлбал, бизнес 12.3 хувь нь уг арга хэмжээг маш сайн, 20.1 хувь нь сайн, харин 42.3% нь нөлөө байгаагүй хэмээн хариулжээ (Зураг 41).

Энэ судалгаанд тогтмол зардлаас чөлөөлөх, нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг чөлөөлөх зэргээс бусад арга хэмжээ нь зорилгодоо хүрээгүй, улсын төсвийг үр дүнгүй зарцуулсан арга хэмжээ болсон гэж дүгнэжээ. Тухайлбал судалгаанд оролцогчдын 75 хувь нь бусад бодлого, арга хэмжээг үр дүн муутай 15 хувь нь мэдэхгүй гэж дүгнэсэн байна.

Зураг 40. Тогтмол зардлын чөлөөлөлтийн нөлөө




Зураг 41. Нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр дүн



Эх сурвалж: MEARC (2022)

Энэ судалгааг гүйцэтгэсэн Монголын эдийн засгийн судалгаа шинжилгээ төв нь бизнес эрхлэгчдээс зээл авч чадаагүй шалтгаануудыг тодруулсан бөгөөд судалгаанд оролцогчдын 40 хувь нь барьцаа хөрөнгө хангалтгүй гэж хариулсан нь зээл авч чадаагүй гол шалтгаан болсон байна. Түүнчлэн санхүүгийн тайлан хангалтгүй (11.4 хувь), зээлийн хүсэлтийг удаашралтай шийдвэрлэсэн, хүнд суртал гаргасан (10 хувь), барьцаа хөрөнгө бодит бус буюу дутуу үнэлэгдсэн (8.6 хувь) болон орлогоо баталгаажуулж чадаагүй (8.6 хувь) зэрэг нь удаах гол шалтгаан болжээ (Зураг 40).

Зураг 42. Зээлийн хүсэлт амжилтгүй болсон шалтгаанууд



Эх сурвалж: MEARC (2022)

Дээр дурдсан макро болон микро түвшний судалгаануудын үр дүнгээс харахад 10 их наядын цогц төлөвлөгөө нь ажлын байрыг олноор хамгаалах үр нөлөө үзүүлж чадсан байна. Гэвч нөгөөтээгүүр, нийлүүлэлтийн тасалдалтаас үүдэлтэй өсөж байсан инфляцыг эрэлт талаас нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлжээ. Энэ нь засгийн газар бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ эдийн засгийн зөвхөн нэг талыг хардаг, ерөнхий тэнцвэрийн нөлөөг авч үзсэн суурь судалгаа хийдэггүй болохыг харуулж байна. Цаашлаад тус цогц төлөвлөгөө нь ажлын байрны дийлэнхийг бүрдүүлдэг, гол тусламж дэмжлэг шаардлагатай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд төдийлөн дэмжлэг үзүүлж чадаагүйг харуулж байна.

3. Бодлогын дүгнэлт, сургамж

Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн талаарх энэхүү урьдчилсан судалгаанаас дараах дүгнэлт, сургамжийг хийж болохоор байна. Үүнд:

1. 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд олгосон санхүүжилт нь Ковид-19 цар тахлын эсрэг тэмцэх, бүх нийтээр дархлаажуулалтад хамрагдах бодлогын хамт ажлын байрыг олноор хамгаалах үр нөлөө үзүүлсэн. Энэ нь эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн нэг зорилго байсан.
2. Уг цогц төлөвлөгөө нь эдийн засаж унасан үед зээлийн өсөлтийг сэргээж, зээлийн хүүг бууруулж, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалтыг дэмжиж, бизнесийн идэвхжилээр дамжин төсвийн орлого бүрдүүлэхэд эерэг нөлөө үзүүлжээ.
3. Гэхдээ эдийн засгийн дотоод идэвхжилийг дэмжих зорилготой санхүүжилттэй урсгал тэнцлийн алдагдал өссөн нь давхацсан байна. Энэ нь гадаад сөрөг шокуудтай орчинд эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангахад сорилт болж байгаа ажээ.
4. Хил гаалийн хязгаарлалт үргэлжилж байгаа үед нийлүүлэлтийн тасалдалтаас үүдэлтэй өсөж байсан инфляцыг эрэлт талаас нэмэгдүүлэхэд энэ цогц төлөвлөгөө томоохон сөрөг нөлөө үзүүлжээ. Хүнс, өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ төдийгүй барилгын материал, орон сууц гэх мэт бүх салбарт үнийн өсөлт хурдтай явагдаж байна.
5. Мөн энэ цогц төлөвлөгөө нь ажлын байрны дийлэнхийг бүрдүүлдэг, гол тусламж дэмжлэг шаардлагатай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд төдийлөн дэмжлэг үзүүлж чадаагүй байна.
6. 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн талаар нэгдсэн тайлан ховор, нарийвчилсан үнэлгээ хийхэд шаардлагатай тоон мэдээлэл нээлттэй биш байна. Өөрөөр хэлбэл, хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ яаж хийгдэж байгаа нь тодорхойгүй байна. Ер нь Засгийн газар авч хэрэгжүүлж байгаа томоохон арга хэмжээ, хөтөлбөрүүдэд мониторинг, үнэлгээ хийлгэдэггүй, сургамж дүгнэлтийг нь дараагийн бодлого шийдвэртээ тусгадаггүй сул тал энэ удаагийн цогц төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдэд ч тодорхой харагдаж байна.

Ашигласан эх сурвалж

- ADB. (2020). *Sustainable Recovery Options for Mongolia's Micro, Small, and Medium-Sized Enterprises*. Philippines: ADB.
- MEARC. (2022). *Challenges for Small and Medium Sized-Businesses: Gender equality and women entrepreneurs*. Ulaanbaatar: Development Solution NGO.
- Б.Уранбилэг. (2022). Ажлын байрыг хадгалах хөнгөлөлттэй зээлийн үр нөлөө. *Үндэсний Статистик Сэтгүүл*, 48-72.
- Дэлхийн Банк. (2022). *Монгол Улсын эдийн засгийн тойм: Шуурган дунд зүг чигээ олохуй*. Вашингтон: Дэлхийн Банк.
- Монголбанк. (2022). *Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн - 2021*. Монголбанк.
- Монголын Банкны Холбоо. (2021). *10 их наядын хөтөлбөр: Бэрхшээл, боломж танилцуулга*. Улаанбаатар: Монголын Банкны Холбоо.
- Сангийн яам. (2021a). *Ажлын байр дэмжих зээлд 22,6 мянган зээлдэгч хамрагджээ*. Сангийн яам: <https://mof.gov.mn/article/entry/226>-ээс Гаргасан
- Сангийн яам. (2021b). *Монгол Улсын нэгдсэн төсөв 2022*. Улаанбаатар хот: Сангийн яам.